

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2021 оны 06 дугаар сарын мэдээлэл

2021.06.23.

“Овоот”

Төрийн удирдлагын чиглэлээр:

1/. Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах ажиллагааг хуулийн хугацаанд амжилттай зохион байгууллаа. Үүнд:

Нийт 4 хэсгийн хороонд 31 төрийн албан хаагч ажиллаж, нэрсийн жагсаалтад 2145 сонгогч бичигдсэнээс 1310 сонгогч саналаа өгч, ирц 61,10 % тай, нэр дэвшигчид У. Хүрэлсүх 87,8 %, С. Эрдэнэ 3,8 %, Д. Энхбат 4,1 %, цагаан санал 4,5 % тай байсан.

2/. Сумын ИТХ-ын ажлын алба: Дарьганга сумын 1-р багийн иргэн "АЙМГИЙН САЙН МАЛЧИН" Халзан овогтой Сүхбаатар нь гэр бүлийн хамт ИТХ-ын үйл ажиллагааг дэмжин ИТХ-ын ажлын албанд мотоцикль хандивласаныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих /эрчимжүүлэх/ зорилгоор мотоцикльг /2,450,000/ сумын Цагдаагийн хэсэгт , Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас / 1,860,000 төг/ ний суурин маяк-1, богино долгионы 10 ширхэг станцыг авч сумын Цагдаагийн хэсэгт гардуулж өгсөн.

3/. Сумын Засаг даргаас: Цар тахлын сэжигтэй тохиолдол батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай сумын Засаг даргын 2021.06.09 ний өдрийн А/78 дугаар захирамжаар зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч 2021.06.10 ны өдрөөс эхлэн 2021.06.27 ны өдрийг хүртэлх хугацаанд иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлан, тэг зогсолтыг тогтоогоод **“Хариу арга хэмжээний төлөвлөлт”**-ийн дагуу **“Тандалтын бүлэг”**-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй сумын Засаг даргын захирамжаар байгуулан, иргэдэд хүнс барааны хүргэлтийн 4 салбар үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

4/. Аймгийн Засаг даргын гэрээний хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд “Сүхбаатарын өнгө” сонины захиалгад 7 байгууллага нийт 101 сонин захиалахаар шийдвэрлэсэн.

5/. 2021 оны 2 дугаар улирлын байдлаар Төрийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл :

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	ЗДТГ	5	1	-	-	5	-
2	НД	39	36	-	-	39	-

3	ХХҮГ	45	40	-	-	45	-
4	Газар	38	20	-	-	38	-
5	БОАЖ	15	13	-	-	15	-
6	Улсын бүртгэл	30	22	-	-	30	-
7	БЗД нарт	54	48	-	-	54	-
	ДҮН	226	180	-	-	226	-

Санхүүгийн чиглэлээр:

1/.“Сайхан хашаа” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх буюу гүйцэтгэх **Сү Дарь / 20210505** дугаартай нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг нээсэн. Тендерт нэг компани материалаа ирүүлсэн бөгөөд “Хянгар констракшн” ХХК нийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж, гэрээ байгууллаа.

2/. 2021 оны эхний хагас жилийн тайлан гарахтай холбогдуулант төсөвт байгууллагуудад өр авлага гаргахгүй байх чиглэлээр анхаарч, Төсвийн мэргэжилтэнтэй холбогдон төсөвт тодорхой хэмжээний зохицуулалтыг хийлээ.

3/. Сүхбаатар аймаг дахь Үндэсний Аудитын газраас төсөвт байгууллагуудын 2020 санхүүгийн тайланд хийсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гарган нэгтгэж хүргүүлээ.

Сургалт сурталчилгааны чиглэлээр.

1/. “Төрийн албаны тухай болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт” -арга зүйн сургалтад 3 албан хаагч ,

2/. “Давсны хэрэглээ, зөв хооллолтын” сургалтад Сургуулийн эмч, тогооч нийт 4 хүн 4 өдрийн

3/. Нийгмийн ажилтныг чадавхжуулах цахим сургалтад ХХҮГ-ын мэргэжилтэн 3 хоног

4/. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд төгсөх ангийн 7 сурагчийг цахим сургалтад хамрууллаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

1/.Сумын Засаг даргын 2021.06.14 ний А/79 дүгээр захирамжаар 2021 оны хагас жилийн малын түүвэр судалгааг 120 өрхөөс авах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллаж байна.

2/. Автотехникийн улсын үзлэгт нийт 325 машин хамрагдаж АТӨЯХ-ийн албан татварт 11,722001 төгрөг, агаар бохирдуулсаны татварт 1550410 төгрөг, нийт 13,272,411 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

3/. Малын индексжүүлсэн даатгалд 10 өрхийг 6 сая төгрөгөөр даатгах арга хэмжээг сумын хэмжээнд Бодь даатгал компанийн төлөөлөл зохион байгуулсан.

4/. 1/. 2021 оны хагас жилийн байдлаар том малын зүй бусын хорогдлын мэдээгээр: 1/ Адуу 155 2/. Үхэр 213, 3/. Хонь 1165 4/. Ямаа 1380, нийт 2913 толгой мал хорогдсон нь нийт малын 2 % ийн хорогдолтой байна.

5/. 2021 оны хагас жилийн байдлаар 22 өрхийн тариаланчид төмс 1,3 гад, 10 өрх хүлэмжийн тариалалт 0,032 га- талбайд тариалаад байна.

Байгаль орчны чиглэлээр.

2021 оны 4 дүгээр сард тус сумын 2 дугаар багт гарсан хээрийн түймрийн хохирол тогтоох ажлын хэсэг сумын Засаг даргын захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдон ажиллаж 18 га газарт 90144000 төгрөгийн хохирлыг тогтоолоо.

Эрүүл мэндийн чиглэлээр:

1/.“Нэг өрх-нэг шинжилгээ” арга хэмжээг 2021.06.24 ний өдрөөс сумын хэмжээний 4 багт эхлүүлэхээр бэлтгэл ажлаа хангаад байгаа ба 2021.06.24 ний өдрөөс эхлэн 16-17 насны 96 хүүхдэд фэйзер вакцин хийх бэлтгэл хангагдсан.

2/. 2021.06.23 ны өдрийн байдлаар ковид-19 цар тахлын батлагдсан тохиолдол 6, нийт 12 том хүн буюу (6 эр, 6 эм) болсон. Үүнээс ойрын хавьтал 82, дам хавьтал 280, эдгээр хүмүүсийг гэрийн ажиглалт тусгаарлалтад аваад байгаа ба үүний 10 нь хүүхэд байна. 6 тохиолдлыг аймгийн эмнэлэгт хүргэсэн.

Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр:

1/. “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлт 3 төсөлд 12 сая төгрөгийн, эргэн төлөгдөхгүй буюу “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” төслийн хүрээнд 2 өрхийг хамруулж 1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.

2/. 2021 оны хагас жилийн байдлаар 19 ажлын байрыг шинээр бий болголоо.

3/. “Нийтийг хамарсан ажил” төслийн хүрээнд 10 хоногт зорилтот бүлгийн 10 иргэнд өдрийн 28000 төгрөг буюу 2,800,000 төгрөгийн санхүүжилтийн ажлыг хэрэгжүүлэхээр болсон.

НЭГТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР